



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/140

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хэсэгчилсэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт Засаг даргын Тамгын газрын эзэмшиж буй 6221002656 нэгж талбарын дугаартай тэжээл бордооны агуулахын зориулалт бүхий 1455 м² газрын 700 м² газрыг тус сумын 3 дугаар багийн иргэн Ганин овогт Цэрэндоржийн Чулуунхүү (ЙБ60021716)-д гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын “Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/183 дугаар захирамжийн Засаг даргын Тамгын газрын холбогдох заалт, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

